**БАТЛАВ:**

**"ЧИНГИС ХААН" ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ЗАХИРАЛ Д.МӨНХБААТАР**

**"БЭЛЧЭЭРИЙН МОНГОЛ МАХ" ХХК – ИЙН ЗАХИРАЛ Б.СОЛОНГО**

***ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ***

**Дугаар №** ХА/05-18

**2018.01.16** **Улаанбаатар хот**

Нэг талаас **"Чингис хаан" Олон улсын нисэх буудал** түүнийг төлөөлж захирал Д.Мөнхбаатар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"Бэлчээрийн монгол мах" ХХК** -г төлөөлж захирал Б.Солонго (цаашид "нийлүүлэгч "гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 01 дугаар сарын 16-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Нийтийн хоол, үйлчилгээний албанд хонины мах 800 кг - нэгж үнэ 5000₮, үхрийн мах 998 кг. - нэгж үнэ 6000₮ (цаашид "бараа" гэх) - ыг **9,988,000** төгрөг /есөн сая есөн зуун наян найман мянга/ -өөр /цаашид гэрээний үнэ гэх/ бараа нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу нийт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн **: 9,988,000 төгрөг /**есөн сая есөн зуун наян найман мянга/ төгрөг **/НӨАТ ороогүй үнэ/**, санхүүжилтийн эх үүсвэр нь "Чингис хаан" ОУНБ-ын өөрийн хөрөнгөөр.

4. Нийлүүлэгч нь Нийтийн хоол үйлчилгээний албанд 2018 оны 01 дугаар сарын 23 ны дотор хонины мах 800 кг, үхрийн мах 998 кг нийлүүлнэ.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

5.1 Гэрээний ерөнхий нөхцөл
5.2 Гэрээний тусгай нөхцөл
5.3 Бараа нийлүүлсэн санхүүгийн баримт
5.4 Шинжилгээний бичиг
5.5 Барааны гарал үүслийн гэрчилгээ
5.6 Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар

Гэрээ нь энд дурдсан барааг нийлүүлэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, нийлүүлэгч нь энэ гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх үүрэг хүлээнэ.

7. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу бараа нийлүүлсэн акт, зарлагын падаан, нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн гэрээний төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

9. Захиалагч барааг зөрчил гологдолтой гэж үзэх, зорчигч үйлчлүүлэгчдээс гомдол гаргах, хэрэглээний явцад чанарын шаардлага хангахгүй тохиолдолд барааг өөр бараагаар сольж өгөх үүрэгтэй.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

| **Захиалагчийг төлөөлж:** | **Нийлүүлэгчийг төлөөлж:** |
|---|---|
| Захиргаа, хүний нөөцийн ерөнхий менежер | “Бэлчээрийн монгол мах” ХХК-ийн захирал |
| С.Энхбаатар | Б.Солонго |
| Санхүү, нягтлан бодох бүртгэлийн элтсийн дарга | |
| Ц. Эрдэнэчимэг | |
| Аж ахуй, хангамжийн тасгийн дарга | |
| Ц.Жавхлантөгс | |

**Талуудын албан ёсны хаяг**

| **Захиалагч:** | **Нийлүүлэгч:** |
|---|---|
| ХУД, 10-р хороо, Буянт-Ухаа дахь “Чингис хаан” ОУНБ | УБ хот, СХД, 12-р хороо, Өнөр хороолол 2-156 тоот |
| Утас: 283021, 283019<br>Факс: 70049617 | Утас: 98082919, 99620291 |

**Харилцах данс**

| **Захиалагч:** | **Нийлүүлэгч:** |
|---|---|
| Голомт банк: 1301041321<br>Худалдаа хөгжлийн банк: 451004193 | Голомт банк: 1415117466 |